

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ганданчойнхорлин хийдийн гэсгүй	Дугаар	L338
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Гурвансайхан сум
Төрсөн газар	Гурвансайхан сум	Төрсөн он	1926
Ажил мэргэжил	Гэсгүй лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шилүүстэйн хийд	Сүм хийдийн дугаар	ӨГХР 022
Одоогийн сүм хийд	Ганданчойнхорлин хийд	Сүм хийдийн дугаар	ДУГС 051
Ярилцлага авсан он сар өдөр	2007 он 7-р сарын 23	Ярилцлага авсан хүн	Жужа

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ганданчойнхорлин хийд, Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Шилүүстэйн хийд

Жужа: Та одоогийн энэ Ганданчойнхорлин хийдийг байгуулсан талаар ярьж өгнө үү?

Гэсгүй: Энэ бол ерэн онд байгуулсан. Хүүчнэ намрын адаг сарын 22-нд хурж эхэлсэн, тэр өдөр нээсэн.

Жужа: Хэдэн ламтай байсан бэ?

Гэсгүй: Эхлээд нээхдээ бол дандаа өвгөчүүл 8, 9 хүн байсан. Тэгээд маргааш нөгөөдөрөөс нь нэмэгдсээр байгаад 25 өвгөн болсон, дандаа хүүчнэ дээр үеийн лам байсан өвгөчүүл.

Жужа: Анхны хамба нь хэн байсан бэ?

Гэсгүй: Манай энэ Элгэн бригадын Гончигжав гэж лам өвгөн анхны хамба нь байсан. тэр өвгөн багадаа баруун Чойрт шавилж Заваа Дамдины шавь болж явсан хүн. Гончигжав лам Элгэн бригадын өөртэй нь хамт баруун Чойрт Чойрын дацанд шавилж явсан Тавхай гэдэг лам өвгөнтэй хамтарч ярилцаад бидэнд хэл өгч бид нар цуглаад сүм хийд сэргээж тухай ярьж тэр өдөр айлын гэрт анхны хурлаа хийж байсан юм. Анхны тэр өвгөчүүл дотор дээд тал нь ерэн гурав, дөрөвтэй, хамгийн бага нь 60 нэлээн гарчихсан би байсан юм. Тэгээд сүүлдээ нэгдлээс нэг гэр гүйж авч хурлаа хураах болсон, бас бага насны банди шавь арваад хүүхэдтэй болсон. Тэгээд нөгөө өндөр настай өвгөчүүл чинь цуваад л цуваад л таалал болцгоосон, дараа жилээс нь Зарим жил хоёр гурваараа ч явна. Нөгөө шавь банди нар яахав, хоёр нь шашны дээд төгссөн. Үгүй энэ шашны дээд төгсөөрөө хөдөө орон нутгаа мартчих юм байна ш дээ. Хот оронд л шингэчихдэг. Үлдсэн нь голцуу эндээ бий. Зарим нь гэр бүл болоод л мал аж ахуйгаа хөөгөөд л иймэрхүү байдалтай л байна. Ирэн очин, заримдаа ч ирээд заримдаа ирэхгүй. Нэг ийм хурал байдаг юм даа. Тэгээд шашны байгууллагаа нэг ажиглаад байхад жаахан эзэнгүйдээд байна уу даа. Нэг сайн дурын хэлбэрээр дээрээс нь үзээд хараад наануу цануу гээд байх юм ховор байна.

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон 1

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ноднин харин хамба Чойжамц хамба ,Сонинбаяр захирал, нэг зайсан гурав ирээд явсан. Би их баярласан. Тэгээд ямархуу хуралхуйтай байна, гээд эргэж тойроод байх нь ховор юм. За хөдөө орон нутагт орлого муутай, төсөв байхгүй болохоор хотын лам нар шиг цалин хөлс байхгүй лам нар ингэхээр мал дээрээ амьны өмч дээрээ энэ хүмүүс байх нь зөв юм , бас нэг амьдрал гэж байна. Тэгээд яахав лам нэртэй, манай дансанд байдаг ирэн очин ийм л хүмүүс байна. Суман дээр одоо тав, зургаан л лам байна. Тэдэнд цогчин хурлын үед жаахан орлогоосоо нэг манз цав хүртээгээд бас нэг дүйчэн өдрүүдийн хурлаар олсон орлогоосоо жаахан хувь хүртээгээд байж байна. Төсөв хөрөнгө байхгүй үчир хийдэд бас манаач сахиул гэж байхгүй. Тэгэхээр амьтан бас шоглоод байх юм. Хонх дамар, бурхан тахлаасаа хүртэл шоглуулсан. Зуны эхэн сарын хорин есөнд арван хангал хурна, намар хайлан хурна, майдар эргэнэ. Шинийн арван таванд магтаал хорин есөнд сахиус тахина. Цагийн хурлууд бол хийнэ. Бусад үед нь хүмүүсийн айлтлалын ном уншина. Бурхан багшийн дүйчэн өдрөөр орн нутгаараа хурал хурдаг. Зулын хорин таван, намрын адаг сарын 22 —ноор маани хурна. Анх энэ хийдийг Заваа Дамдингийн хоёр шавь Гончигжав, Тавхай гуай хоёр санаачилсан болоод ч тэр үү, чойрын ном ялангуяа Заваа Дамдины зохиосон номнуудыг их уншдаг, чогууд. Уншлагын дэг жагя ая дан нь хүртэл чойрын хийдтэй их төстэй хийгдсэн байдаг. Энэ нь одоо ч уламжлагдаж байна. Хотын хүрээ хийдээс шал ондоо. Энэ дуганууд яг 1993 оны намрын адаг сарын 22-нд боссон.

Жужа: Гадаах хоёр суваргыг хэн хэзээ босгосон бэ?

Гэсгүй: Эхнийхийг нь 1995 онд манай анхны их лам Гончигжав багштан Тавхай багш хоёр Заваа Дамдин багшдаа зориулж босгосон. Дараачийхыг нь хоёр дахь хамба 2000 онд босгосон.

Жужа: Гурвансайхан сумын нутагт байсан хүүчнэ хийд хурлын тухай та мэдэх зүүлээ ярьж өгнө үү?

Гэсгүй: Би энэ сумын нутагт энэ газар ийм нэртэй хурал хийд байсан гэж сонссон. Түүнийгээ зааж өгөхөөс биш тэр тэдэн дугантай, тэдэн ламтай, тийм сахиустай хийд орон байсан гэдгийг юу ч мэдэхгүй. Шавилч ч суугаагүй барааг нь ч хараагүй. Тийм болохоор энэ талаар мэдэхгүй.

Жужа: Та өөрөө хэрхэн яаж лам болсон тухайгаа ярьж өгнө үү?

Гэсгүй: За миний амьдралын түүх лам болсон тухай яривал бүхэл бүтэн зохиол шиг юм гарна. За би зөвхөн лам болсон тухайгаа л товч хэлэе. Би Өмнөговийн хүн. 1926 онд төрсөн. 1930-аад онд ардын засгийн эхээр нугалаа гарч олон зуун айл өрх хэдэн мянган хүмүүс Өмнөговийс урагшаа хил давж Одоогийн өвөрмонголын Алша нутаг руу хил давж дүрвэсэн. Тэр хүмүүсийн дотор энгийн ард сум, захиргааны тамгын дарга нар, лам нар том том мандатан хувилгаан лам нар хүртэл явсан. Тэр үед би 4 настай, их нүүдлээр гэр оронтойгоо хил давсан юм билээ. Тэгэхдээ манай нутгийнхан өөрийн нутгийн хийдийн бурхан сахиус шүтээн ном судраа аваад явсан байна.

Жужа: Өмнөговийн аль хийд вэ?

Гэсгүй: Шүлүүтэйн хийд гэж байсан. Тэр хийдийн гол шүтээн Гомбо сахиус , энэ бурхнаа арганд хийгээд тэмээнд ачичихсан, мань мөтийн жоохон хүүхдүүдийг бас цуг ачичихсан нүүж явсан гэдэг. Одоо энэ Гомбо шүтээн гандангийн их дуганы баруун хойд өнцөгт яг тэр үеийн модон гүнгэрваатайгаа байж байдаг. Ингээд энэ Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон 2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

нүүдлээр Өмнөговийс гадна Баянхонгор, Говь-Алтай тэр үеийн Түшээ гүн, Балдан засгийн олон арван айл өрх хүн ард нүүж гарсан. Тэгээд яахав, Алша нутаг эзгүй, засаг зхиргаа байхгүй. Тэнд очсон лам нар гэр дуганд шүтээнээ тахиж, хурал уншлагаа эхэлж хийд байгуулсан юм гэнэ лээ.

Энхбаяр: Тэр амар нэртэй хийд байгуулсан бэ?

Гэсгүй: Дилав гэгээний хийд нэртэй хийд байгуулсан. Энэ нүүдлээр манай Өмнөговийн хувилгаан Очирдара лам бас дүрвэн гарсан. Тэр хувилгаан лам энэ хийдийн нэрийг өгсөн гэдэг. Дилав гэгээн гэдэг чинь Завханы хүн. Дилав хутагт. Зураг нь тэр байна. За ингээд би 1936 онд арван настайдаа энэ хийдэд шавилан ном заалгаж байгаад 9 жил болж 1945 онд 19 настайдаа Ар монголд орж ирсэн. Тэгээд Дорноговийн Их хэтийн Нүдэнгийн жасд очиж хоёр гурван жил ном хураад хурал хаалгасан. Тэгэхээр нь хэдэн өвгөчүүдийн хамт ганданд очиж ном үзээд сууж байтал улс төрийн хэрэгтэн болж татагдсан. Надтай ганданд сууж байсан хүмүүс гэвэл Чимэддорж, Дагвадорж, Балдорж нар гээд нэг зиндааны хүмүүс байсан. одоо ганцан Чимэддорж л харагдаж байна лээ. Чи таних уу , үгүй юу. Намайг улс төрийн хэрэгт татаад гадаадад дүрвэж эх орноосоо урвасан , лам байсан, японы цэрэгт алба хаасан гэсэн ял тулгасан. Би эх орноосоо гарахдаа 4 настай байсан, юугаа ч мэдэхгүй. Хаашаа ч яваагаа мэдэхгүй нялх хүүхэд байсан гэж хэлэхээр тэр хамаагүй. Ээжийнхээ гэдсэнд байсан ч гэсэн хил даваад л нүүсэн бол эх орноосоо урвасан гэж үзнэ гээд л дотоод яамныхан ял тулгана. За лам байсан нь бол тодорхой, энэ бол ер нь нүүх хаах юм байхгүй. Японы цэрэгт алба хаасны тухайд намайг 18- тай байхад эх орондоо ирэхийн үрд жил Өвөрмонгол Японд эзлэгдсэн байсан. тэгээд Япончууд 18-тай залуусыг хүчээр дайчлан 10 сарын хугацаагаар цэргийн сургууль хийлгэж байсан. Үүнд би дайлагдсан. Энэ нь тэр японд цэрэг алба хаасан гэдэг нь. За тэгээд улстөрийн хэргээр 6 жил шоронд хоригдсон. Тэгээд нэг зарлигаар суллагдсан. Тэгтэл харин бүр 1990 онд намайг хэлмэгдүүлсэн байна, цагаатгалаа гээд нэг сая төгрөг өгсөн. Мөн янз бүрийн их юм үзсэн дээ. Залуу ч байж, 6 жил шоронд сууж хийсэн ажлын хөлс нэг сая төгрөгөнд хүрэхгүй ч гэсэн яахав ээ, яахав. Ийм л хөтэй түүхтэй хүн дээ. Шоронгоос гараад төмөр замд 5 жил ажиллаад тэгээд энд ирсэн. Энд ээж байна, ах дүү нар энд байна. Тэгээд залуудаа ээж амьтан ах дүүгээ бараадыг гээд энд ирсэн. Одоо нэг өргөмөл хүүтэй, жаргаж байна аа, жаргаж байна. Арван жил энд гэсгүй хийж байна. Тэгээд л энд хүүхдүүдтэй хураад л болж л байна аа , болж л байна. Тэгээд ерэн онд тэтгэвэрт гараад л энэ хийдтэй холбогдсон.

Жужа: За баярлалаа.

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соблын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон 3